



ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЕБДС

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Аудитын газрын дарга,
Тэргүүлэх Аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582
[И-мэйл](#)

СТА-ын ахлах аудитор
Ц.Базарсад
Утас: 70272287
И-мэйл Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	7
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	7
• Аудитын санал дүгнэлт	8

Ерөнхий боловсролын сургуулийн 2013 оны Санхүүгийн тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид ЕБДС-ийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба ЕБДС-ийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд цэцэрлэг тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. 2013.11.07-нд мөн 1680.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг шилжүүлж, бараа материалын тайланд нүүрсээ авахдаа 1 тн-ыг нь 160.0 мянган төгрөг болгон өсгөж 240.0 мянган төгрөгийг 2013.11.12-нд үнийн зөрүү гэж нэхэмжлэн авсан зөрчил илэрлээ.
2. Цалингийн зардлаас Б.Одсүрэнгийн эхийн чөлөөтэй байх хугацааны, О.Оюунгэрэлийн жирэмсэн, амаржсаны тэтгэжтэй байх хугацаанд хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлогоос шимтгэл тооцож төлөөгүй 561.6 мянган төгрөгийн НДШимтгэл 56.9 мянган төгрөг, түүнд ноогдох алданги 28.4 мянган төгрөгийн актын төлбөрийг төлсөн байна.
3. 2013 онд нийт 25928 хүүхэд өдөрт 42266.8 мянган төгрөгний хоолны зардал гаргажээ. Энэ нь нэг хүүхэд өдөрт 1630 төгрөгний

зардал гаргаж, Засгийн газраас тогтоосон нэг хүүхэд өдрийн хоолны зардал 1650 төгрөгнөөс 20 төгрөгөөр буюу жилдээ нийт 518.6 мянган төгрөгөөр дутуу хооллосон байна.

4. Үдийн цайны зардалд 21993.5 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 21502.2 мянган төгрөг зарцуулсаныг бараа материалын тайлангийн жинхэнэ зарлагатай тулгахад 19644.0 мянган төгрөг буюу 2349.5 мянган төгрөгийн хэмнэлттэй гарч төвлөрүүлээгүй байна. Үдийн цайнд өдөрт 1 хүүхдэд 600 төгрөг зарцуулахаас 595 төгрөг зарцуулж жилдээ нийт 165.0 мянган төгрөгийг дутуу олгосон байна.
5. Хоолны зардалд 31721.1 мянган төгрөг батлагдсанаас 31721.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, гүйцэтгэлээр 32046.7 мянган төгрөг зарцуулсан байна. Дотуур байрны хүүхдэд өдөрт 2315 төгрөг зарцуулахаас 2322 төгрөг зарцуулж өдөрт 7 төгрөг буюу жилдээ 96.9 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна.
6. Үдийн цайны зардлын хэмнэлт 2349.5 мянган төгрөг хэмнэлтийг төвлөрүүлээгүй бүлэг хооронд нь шилжүүлэн зарцуулсан нь Сангийн сайдын 73-р тушаалын 5-д заасны дагуу зохицуулалт хийгээгүй, БСШУСайд, ССайдын 2009.12.14-ны 560/276 тоот тушаалаар батлагдсан Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын цэцэрлэгийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, МСҮТөвийн сургалцагчдын тэтгэлэгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журмын 2-ын 4-д Төв төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хэмнэлтийн дансанд зардлын хэмнэлтийг төвлөрүүлнэ, 6-д Цэцэрлэгийн эрхлэгч, цэцэрлэгийн захирал нь

тухайн улиралд гарсан зардлын хэмнэлтийг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, 4-р улирлын зардлын хэмнэлтийг 12 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх дансанд шилжүүлж байна гэснийг тус тус зөрчсөн байна.

Шууд захирагчаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа
- Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт 2014.03.14-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч Д.Нарангэрэл бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Төв Аймгийн Аудитын Газар

2014.03.14

Танилцуулга

1. Бид Аймгийн Цээл сумын сургуулийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Цээл сумын сургуулийн шууд захирагч энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Цээл сумын сургууль тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Аймгийн Цээл сумын сургуулийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Цээл сумын сургуулийн захиралд тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Цээл сумын сургуулийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Байгууллагын дотоод хяналт шалгалтын багууд 2013 онд хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж, гүйцэтгэлийг хамт олондоо тайлагнаж, мэдээллийг ил тод байдлын самбар дээр тавьж байгууллагын хамт олонд танилцуулж хэвшсэн байна.

Дотоод хяналтыг графикийн дагуу хөрөнгийн тооллого хийж гарсан зөрчил дутагдлыг байгууллагын удирдлагад танилцуулж арга хэмжээ авч ажилласан байна. Бараа материалын татан авалтанд хяналт хийж, ирсэн барааны хугацааг нарийн сайн үзэж шалгадаг байна. Мөн ашиглалтгүй хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, тооллогоор дутагдсан хөрөнгийг төлүүлэх, эвдэрсэн хөрөнгийг засаж сэлбүүлэх ажил зохион байгуулж ирсэн байна.

Түрээсийн сурах бичгийн тооцоог шалгаж удирдлагад танилцуулж, төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт

Дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулж, хэрэгжилтийг мөрдүүлж ажиллах

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байх

Үдийн цай, хоолны зардлыг батлагдсан нормативын дагуу бодож байх

Зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх

Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж акт үйлдсэн байх гэсэн зөвлөмжүүдийн мөрөөр ажил зохион байгуулаагүй, хэрэгжүүлэх талаар хангалтгүй ажилласан байна.

2. Орлогын талаар

Мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 470356.8 мянган төгрөгийн эх үүсвэр, төгрөг үндсэн бус үйл ажиллагааны орлого 126.7 мянган төгрөг нэмэлт санхүүжилтээр авьяас хөтөлбөрийн 2253.8 мянган төгрөг, листний үлдэгдэл 48.2 мянган нийт 472785.5 мянган төгрөг орлогоор тайлагнагдсан. Мөн мөнгөн гүйлгээний тайланд 4370.2 мянган төгрөгийн листний мөнгийг орлогоор бүртгэсэнийг залруулж бууруулах бичилтээр тайлагнуулсан.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар урсгал санхүүжилт 470356.8 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 2230.0 мянган төгрөгийн малын нас дэвшилттэй холбоотой орлого, 126.7 мянган төгрөг өөрийн орлого, нэмэлт санхүүжилтийн дансны орлого 2302.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлого 20669.0 мянган төгрөг, Бүгд 495684.5 мянган төгрөгийн орлогоор тайлагнагдсан байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

Харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн данс 0 төгрөгийн үлдэгдэлтэй хяналтын хуулга байгаа боловч төрийн сан байгууллагын цэвэр мөнгөн гүйлгээний орлого, зарлага, үлдэгдлийг албан ёсоор өссөн дүнгээр баталгаажуулдаггүй байна.

Хяналтын түвшингийн хуулгаар урсгал санхүүжилт 470356.8 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний цэвэр зарлага 496730.2 мянган төгрөг, орлогоос бууруулах бичилтээр 26373.4 мянган төгрөг тайлагнагдахыг мөнгөн гүйлгээний журналд бичилгүйгээр шууд орхин тайлагнасан байна.

Ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр 10 сарын дуустал сар бүр 10 хувиар бодож авсан 906.7 мянган төгрөгөөс НДШ-90.6 мянган төгрөг, ХАӨАТ-81.6 мянган төгрөгийг хасаж 734.4 мянган төгрөгийг төлүүлэхээр акт бичигдэж бүрэн төлсөн.

Ажилчдын ур чадварын нэмэгдлийг олгохдоо дүгнэсэн боловч баримтын бүрдэл дутуу байлаа. Томилолтын гүйцэтгэлийг хаахдаа удирдлагын зүгээс ажил гүйцэтгэсэн тухай дүгнэлтэнд тэмдэглэл хийлгүйгээр зөвшөөрөв гэсэн цохолт хийн олгосон байна.

Сургалтын менежер С.Отгонбаяр, захирал Лхамноров нарт 2013.08.23-нд 4, 5 тоот төлбөрийн хүсэлтээр 72.0 мянган төгрөгийн томилолт олгосон боловч захирал Лхамноровын 36.0 мянган төгрөгийн томилолтын хуудасгүйгээр томилолт олгосонд акт бичигдэж бүрэн төлөгдсөн.

Мөнгөн гүйлгээний журналаас түүврийн аргаар нүүрс, хоолны үнийн шилжүүлгээр хийсэн гүйлгээнүүдийн анхан шатны баримтын бүрдэлийг шалгахад :

- ✚ Иргэн Батмөнхийн нүүрс нийлүүлсэн 6912.5 мянган төгрөгийн гүйлгээнээс 2013.10.07-нд 1 тонныг нь 140.0 мянган төгрөгөөр тооцон 1680.0 мянган төгрөгийг нэхэмжлэхийн дагуу шилжүүлж, орлогыг бараа материалын тайланд бүрэн тусгасан. 2013.11.07-нд мөн 1680.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг шилжүүлж, бараа материалын тайланд нүүрсээ авахдаа 1 тн-ыг нь 160.0 мянган төгрөг болгон өсгөж 240.0 мянган төгрөгийг 2013.11.12-нд үнийн зөрүү гэж нэхэмжлэн авсан зөрчил илэрлээ.

- ✚ Баясгаланд 2013.11.22-нд 607.6 мянган төгрөг нүүрсний үнэнд шилжүүлж 4.340 кг нүүрсийг 140.0 мянган төгрөгийн үнэтэйгээр бараа материалын тайланд бүрэн орлого авсан байна.
- ✚ Ник дундад бүсэд 2013.11.26-нд хоолны зардлаас 70.0 мянган төгрөг, үдийн цайны зардлаас 70.0 мянган төгрөг шилжүүлж хүнсний материал татан авахад зарцуулсан шатахууныг хоолны зардалд нэмж тооцсон байна.
- ✚ Номин тав ХХК-ын 2013.12.19-нд шилжүүлсэн хоолны зардлаас 827.5 мянган төгрөг, үдийн цайны зардлаас 651.4 мянган төгрөг шилжүүлсэн бараа материалын тайланд авсан орлоготой тулгаж үзэхэд үдийн цайны мөнгөнөөс хоолны зардалд 86.1 мянган төгрөгийн материал гүйлгэн зарцуулсан байна. Үүний учрыг нягтлан бодогч Нарангэрэлээс тодруулахад захиалсан бараагаа авахад зарим үед захиалгын бараа байхгүй учраас төлсөн мөнгөндөө тохируулсан байгаа материалаас авч хоорондоо гүйгдэж байгаа боловч жилийн эцэстээ тохирдог гэсэн тайлбар өгсөн.

Цалингийн зардлаас Б.Одсүрэнгийн эхийн чөлөөтэй байх хугацааны, О.Оюунгэрэлийн жирэмсэн, амаржсаны тэтгэжтэй байх хугацаанд хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлогоос шимтгэл тооцож төлөөгүй 561.6 мянган төгрөгийн НДШимтгэл 56.9 мянган төгрөг, түүнд ноогдох алданги 28.4 мянган төгрөгийн актын төлбөрийг төлсөн байна. Үдийн цайны зардалд 21993.5 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 21502.2 мянган төгрөг зарцуулсаныг бараа материалын тайлангийн жинхэнэ зарлагатай тулгахад 19644.0 мянган төгрөг буюу 2349.5 мянган төгрөгийн хэмнэлттэй гарч төвлөрүүлээгүй байна. Үдийн цайнд өдөрт 1 хүүхдэд 600 төгрөг зарцуулахаас 595 төгрөг зарцуулж жилдээ нийт 165.0 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Хоолны зардалд 31721.1 мянган төгрөг батлагдсанаас 31721.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, гүйцэтгэлээр 32046.7 мянган төгрөг зарцуулсан байна. Дотуур байрны хүүхдэд өдөрт 2315 төгрөг зарцуулахаас 2322 төгрөг зарцуулж өдөрт 7 төгрөг буюу жилдээ 96.9 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна.

4. Бараа материалын талаар

Бараа материалын оны эхний үлдэгдэл 31046.0 мянган төгрөг, тайланд онд нэмэгдсэн 98250.0 мянган төгрөг, 96468.4 мянган төгрөг зарцуулж, 818.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 32827.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Халаалтын зардлыг нарийвчилан тооцож үзэхэд НРЖ-30 тогооны цагийн нормоор нь нүүрсийг тооцоход жилдээ 362.4 тонн зарцуулахаар байхад зарцуулсан нь 224.1 тонныг зарцуулж, 138.3 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2013 онд төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 21993.5 мянган төгрөгийн батлагдсан төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 21502.2 мянган төгрөг зарцуулж, 491.4 мянган төгрөгийн хэмнэлттэй байна. Дотуур байрны хүүхдийн хоолонд 31721.1 мянган төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 31721.0 мянган төгрөг зарцуулж, 0.95 мянган төгрөгийн хэмнэлттэй байна. Жолоочийн тооцоо гэж боддоггүй, өөрийн унаа гэж байхгүй учраас тухайн тээвэр хийсэн жолоочид бинзин олгосоноороо няравын тайлангаар зарлага бичигдэж байна.

5. Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант онд оны эхний үлдэгдэл 1336859,6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр авсан номын фонд 365,6 , хандив тусламжаар 18059,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж авч, Сумын ИТХ ын шийдвэрээр акталсан хөрөнгө 16033.9 мянган төгрөг, оны эцсийн үлдэгдэл 1339250.3 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Сургуулийн 40 жилийн ойд 35 төгсөгчдөөс ирсэн 20669.0 мянган төгрөгийн хандивын хөрөнгийг машин тоног төхөөрөмжинд 9629.0 мянган төгрөг, тавилга эд хогшилд 8430.0 мянган төгрөг, бусад хангамжийн материалд 2610.0 мянган төгрөгийг тус бүр ангилалын дагуу данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

Жилийн эцсийн тооллогын комиссыг Магсар, Даариймаа Дуламсүрэн нарын бүрэлдэхүүнтэй 2013.11.19-ны б/40 захирлын тушаалаар томилогдсон комисс 2013.12.01-нээс 2013.12.15-ний хооронд сургуулийн бүх анги танхим байрыг хамруулан явуулж чанартай хийж гүйцэтгэсэн байна.

Тооллогын комиссын бүрэлдэхүүн тооллогын бүртгэлийг нэгтгэн гаргаж, нэгтгэлийн дагуу программд шивж оруулан тооллогын бүртгэл нэг бүртэй тулган хэвлэн гаргаж тооллогын комиссуудаар гарын үсэг зуруулан баталгаажуулсан байна.

Хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хийхээр хуульд заасан боловч тооллогыг эхний хагас жилээр тооллого хийдэггүй, жилийн эцэст тооллого хийсэн байна.

Элэгдлийг санхүүгийн программаар бодуулж бичилтийг хийж гүйцэтгэсэн байна.

6. Авлага, өглөгийн талаар

Тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэхийг шалгахад Цахилгаан шугам сүлжээний газартай 10884,6 мянган төгрөгийн зардлын бичилт, төлөлтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар ажил олгогчоос төлөх НДШимтгэлд 31951.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 31072.9 мянган төгрөгний НДШ-ийн зардал гарч, батлагдсан зардал 878.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн харагдаж байна.

2013 онд НДСанд ажил олгогчоос 31072.9 мянган төгрөг, даатгуулагчаас 30332.2 мянган төгрөг, бүгд 61405.1 мянган төгрөг, нийт 61378.0 мянган төгрөгний НДШимтгэл төлөхөөс 61405.1 мянган төгрөг төлж, 27.1 мянган төгрөгний өглөгийг тайланд тусгасан байна.

ХАОАТ-ын тайлан ирүүлээгүй тул тулгалт хийгээгүй болно.

7. Цалингийн талаар

Цалин, үр дүнгийн урамшил, гэрээт ажилтны цалин зэрэгт нийт 292364.4 мянган төгрөгний зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 292364.4 мянган төгрөгний цалин, хөлс, урамшил олгож батлагдсан зардлаас хэтрэлт хэмнэлтгүй байна.

Ажилтнуудад Үр дүнгийн урамшууллыг олгохоор гаргасан тушаалдаа ажлыг нь зохих ёсоор дүгнэж дүгнэсэн дүгнэлтээ хавсаргасан байна

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 7 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

6. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- + Хоорондын тооцоо бүрийг улирлын эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулж хэвших
- + Тооцоо бодолт, тооллогыг цаг тухай бүрд нь чанартай хийж гүйцэтгэж байх
- + Сар бүр харилцахын журналыг анхан шатны баримтанд хэвлэж үдэж байх
- + Харилцах, кассын баримтын оны эхнээс нэг дугаараар дугаарлаж хэвших

7. Эдгээр асуудлуудыг ААГ болон Цээл сумын сургууль авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

8. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

9. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд цэцэрлэгийн удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

10. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ААГ

2014.03.13